СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2026/115/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх
Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар
Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № СЭА-2026/115/НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ______________-т

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ДӨРӨВДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.НАРАНГЭРЭЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Мандал сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд 22,630.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 128 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Тод-руулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4 | 280,144,221.44 | 158,126,927.37 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 280,144,221.44 | 158,126,927.37 |
| 3121 | Төгрөг | | 280,144,221.44 | 158,126,927.37 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 280,144,221.44 | 158,126,927.37 |
| 33 | АВЛАГА | 5 | 805,440.30 | 52,368.22 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 805,440.30 | 52,368.22 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6 | 49,035,300.32 | 76,300,810.87 |
| 351 | Түүхий эд материал | | 3,947,246.90 | 6,550,060.90 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | | 3,823,691.90 | 6,390,405.90 |
| 3513 | Эм боох материал | | 123,555.00 | 159,655.00 |
| 354 | Хангамжийн материал | | 45,088,053.42 | 69,750,749.97 |
| 3542 | Аж ахуйн материал | | 1,008,996.00 | 10,414,070.00 |
| 3546 | Хүнсний материал | | 1,698,659.00 | 1,583,564.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | | 42,380,398.42 | 57,753,115.97 |
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 329,984,962.06 | 234,480,106.46 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7 | 4,627,359,267.53 | 4,580,193,632.89 |
| 392 | Биет хөрөнгө | | 4,594,464,933.99 | 4,544,669,299.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 4,596,872,685.00 | 4,596,872,685.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (528,321,116.84) | (619,984,038.87) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 491,575,691.17 | 545,057,607.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (170,857,510.15) | (163,965,434.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 319,118,445.87 | 343,338,445.87 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (133,721,543.09) | (183,561,692.30) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 14,112,000.00 | 14,112,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (8,396,700.76) | (4,195,425.26) |
| 39217 | Ном | | 14,082,982.79 | 16,995,151.75 |
| 393 | Биет бус хөрөнгө | | 32,894,333.54 | 35,524,333.54 |
| 39301 | Програм хангамж | | 2,180,000.00 | 2,630,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (2,221,666.46) | (41,666.46) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 32,936,000.00 | 32,936,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 4,627,359,267.53 | 4,580,193,632.89 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 4,957,344,229.59 | 4,814,673,739.35 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9 | | 4,440,500.04 |
| 413 | Өглөг | | | 4,440,500.04 |
| 4136 | Бусад өглөг | | | 4,440,500.04 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | | 4,440,500.04 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | | 4,440,500.04 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 4,957,344,229.59 | 4,810,233,239.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 32,936,000.00 | 32,936,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | | 32,936,000.00 | 32,936,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | | 4,924,408,229.59 | 4,777,297,239.31 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | | 4,924,408,229.59 | 4,924,408,229.59 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | | (147,110,990.28) |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 4,957,344,229.59 | 4,810,233,239.31 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 4,957,344,229.59 | 4,814,673,739.35 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Тод-руулга | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 3,405,399,243.11 | 3,975,244,872.71 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | 3,130,138,800.00 | 3,683,063,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | | 3,683,063,300.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 19,024,500.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | 3,111,114,300.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | 275,260,443.11 | 292,181,572.71 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 275,260,443.11 | 292,181,572.71 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 283,691,166.00 | 203,659,109.48 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 283,691,166.00 | 203,659,109.48 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 21,936,300.00 | 5,474,980.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 19,346,300.00 | 174,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 2,590,000.00 | 5,300,980.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 261,754,866.00 | 160,714,223.68 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | | 37,469,905.80 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2 | 3,689,090,409.11 | 4,178,903,982.19 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 3,487,530,699.04 | 4,326,014,972.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 3,357,588,248.94 | 4,132,381,610.47 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 2,371,529,785.06 | 2,993,343,142.58 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,387,569,507.64 | 1,727,458,344.00 |
| 210102 | Нэмэгдэл | | 903,487,147.02 | 1,074,620,203.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | 84,952,315.99 |
| 210104 | Урамшуулал | | 80,473,130.40 | 106,312,279.16 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 292,982,872.76 | 347,758,524.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 193,847,113.11 | 239,497,952.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 24,809,760.71 | 29,758,590.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 12,404,830.36 | 15,425,431.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 12,384,193.72 | 12,615,469.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 49,536,974.86 | 50,461,079.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 266,474,743.11 | 282,181,572.71 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 18,581,741.76 | 26,253,089.09 |
| 210302 | Түлш, халаалт | | 207,851,138.01 | 207,851,025.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 40,041,863.34 | 48,077,458.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | 16,909,266.25 |
| 210404 | Ном, хэвлэл | | | 16,909,266.25 |
| 2105 | Норматив зардал | | 35,220,991.00 | 61,632,390.50 |
| 210502 | Хоол, хүнс | | 35,220,991.00 | 61,632,390.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 11,369,600.00 | 9,994,500.00 |
| 210604 | Урсгал засвар | | 11,369,600.00 | 9,994,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 53,402,719.53 | 65,899,750.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 9,247,502.00 | 174,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 44,155,217.53 | 65,725,750.04 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 326,607,537.48 | 354,662,464.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 77,248,076.32 | 110,141,706.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 21,111,590.00 | 16,820,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 228,247,871.16 | 227,699,858.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 129,942,450.10 | 193,633,362.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 129,942,450.10 | 193,633,362.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 116,546,450.10 | 178,923,662.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 13,396,000.00 | 14,709,700.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3 | 3,487,530,699.04 | 4,326,014,972.47 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | | 201,559,710.07 | (147,110,990.28) |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | | 201,559,710.07 | (147,110,990.28) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,427,335,543.11 | 3,980,719,852.71 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 21,936,300.00 | 5,474,980.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 21,936,300.00 | 5,474,980.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 21,936,300.00 | 5,474,980.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,346,300.00 | 174,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,590,000.00 | 5,300,980.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,405,399,243.11 | 3,975,244,872.71 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,130,138,800.00 | 3,683,063,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 3,683,063,300.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,024,500.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 3,111,114,300.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 275,260,443.11 | 292,181,572.71 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 275,260,443.11 | 292,181,572.71 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,260,618,501.68 | 4,102,737,146.78 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,260,618,501.68 | 4,102,737,146.78 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,130,315,342.68 | 3,906,447,070.78 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,371,529,785.06 | 2,992,590,070.50 |
| 210101 | Үндсэн цалин | 1,387,569,507.64 | 1,727,458,344.00 |
| 210102 | Нэмэгдэл | 903,487,147.02 | 1,074,620,203.43 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 84,952,315.99 |
| 210104 | Урамшуулал | 80,473,130.40 | 105,559,207.08 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 293,788,313.06 | 347,758,524.07 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 194,652,553.41 | 239,497,952.73 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 24,809,760.71 | 29,758,590.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,404,830.36 | 15,425,431.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,384,193.72 | 12,615,469.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 49,536,974.86 | 50,461,079.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 266,474,743.11 | 282,181,572.71 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,581,741.76 | 26,253,089.09 |
| 210302 | Түлш, халаалт | 207,851,138.01 | 207,851,025.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 40,041,863.34 | 48,077,458.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,802,660.00 | 61,427,295.50 |
| 210502 | Хоол, хүнс | 34,802,660.00 | 61,427,295.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,785,700.00 | 10,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,785,700.00 | 10,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 53,402,719.53 | 64,914,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,247,502.00 | 174,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 44,155,217.53 | 64,740,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,531,421.92 | 147,575,308.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 77,492,346.92 | 127,475,408.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,039,075.00 | 20,099,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 130,303,159.00 | 196,290,076.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 130,303,159.00 | 196,290,076.00 |
| 213205 | Тэрээс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 116,907,159.00 | 181,580,376.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,396,000.00 | 14,709,700.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 166,717,041.43 | (122,017,294.07) |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 76,658,425.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 76,658,425.00 | |
| 222001 | Тоног төхөөрөмж | 43,903,425.00 | |
| 223001 | Бусад хөрөнгө | 32,755,000.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (76,658,425.00) | |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 90,058,616.43 | (122,017,294.07) |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 280,144,221.44 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 158,126,927.37 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **32,936,000.00** | | **4,924,408,229.59** | **4,957,344,229.59** |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | (147,110,990.28) | (147,110,990.28) |
| **19** | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **32,936,000.00** | | **4,777,297,239.31** | **4,810,233,239.31** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 4,296,665,500.00 | 3,975,244,872.71 | 321,420,627.29 | 92.5 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,002,377,600.00 | 3,683,063,300.00 | 319,314,300.00 | 92.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,002,377,600.00 | 3,683,063,300.00 | 319,314,300.00 | 92.0 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 294,287,900.00 | 292,181,572.71 | 2,106,327.29 | 99.3 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 294,287,900.00 | 292,181,572.71 | 2,106,327.29 | 99.3 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 6,093,280.00 | 5,474,980.00 | 618,300.00 | 89.9 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 792,300.00 | 174,000.00 | 618,300.00 | 22.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,300,980.00 | 5,300,980.00 | | 100.0 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,302,758,780.00 | 3,980,719,852.71 | 322,038,927.29 | 92.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,296,665,500.00 | 4,102,737,146.78 | 193,928,353.22 | 95.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,090,973,200.00 | 3,906,447,070.78 | 184,526,129.22 | 95.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,101,901,200.00 | 2,992,590,070.50 | 109,311,129.50 | 96.5 |
| 210101 | Үндсэн цалин | 1,918,916,200.00 | 1,727,458,344.00 | 191,457,856.00 | 90.0 |
| 210102 | Нэмэгдэл | 1,106,556,700.00 | 1,074,620,203.43 | 31,936,496.57 | 97.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 84,952,315.99 | (84,952,315.99) | |
| 210104 | Урамшуулал | 76,428,300.00 | 105,559,207.08 | (29,130,907.08) | 138.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 389,753,100.00 | 347,758,524.07 | 41,994,575.93 | 89.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 265,032,100.00 | 239,497,952.73 | 25,534,147.27 | 90.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 31,180,300.00 | 29,758,590.00 | 1,421,710.00 | 95.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,590,100.00 | 15,425,431.90 | 164,668.10 | 98.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,590,100.00 | 12,615,469.93 | 2,974,630.07 | 80.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,360,500.00 | 50,461,079.51 | 11,899,420.49 | 80.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 284,287,900.00 | 282,181,572.71 | 2,106,327.29 | 99.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,059,700.00 | 26,253,089.09 | (1,193,389.09) | 104.8 |
| 210302 | Түлш, халаалт | 210,000,000.00 | 207,851,025.62 | 2,148,974.38 | 99.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 49,228,200.00 | 48,077,458.00 | 1,150,742.00 | 97.7 |
| 2105 | Норматив зардал | 66,737,000.00 | 61,427,295.50 | 5,309,704.50 | 92.0 |
| 210502 | Хоол, хүнс | 66,737,000.00 | 61,427,295.50 | 5,309,704.50 | 92.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 | | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 66,533,700.00 | 64,914,300.00 | 1,619,400.00 | 97.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 792,300.00 | 174,000.00 | 618,300.00 | 22.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 65,741,400.00 | 64,740,300.00 | 1,001,100.00 | 98.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 171,760,300.00 | 147,575,308.00 | 24,184,992.00 | 85.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 151,660,400.00 | 127,475,408.00 | 24,184,992.00 | 84.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,099,900.00 | 20,099,900.00 | | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 205,692,300.00 | 196,290,076.00 | 9,402,224.00 | 95.4 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 205,692,300.00 | 196,290,076.00 | 9,402,224.00 | 95.4 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 190,982,600.00 | 181,580,376.00 | 9,402,224.00 | 95.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,709,700.00 | 14,709,700.00 | | 100.0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 4,296,665,500.00 | 4,102,737,146.78 | 193,928,353.22 | 95.5 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 280,144,221.44 | (280,144,221.44) | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 158,126,927.37 | (158,126,927.37) | |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 91 | 91 | | |
| 6 | Удирдах ажилтан | 1 | 1 | | |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 61 | 61 | | |
| 8 | Үйлчлэх ажилтан | 26 | 26 | | |
| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | | |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 484,242.8 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа.Үүнд:

- *Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 50 нэр төрлийн 99,470.1 мянган төгрөгийн хөрөнгийг /Нийт хөрөнгийн 2.1 хувь/ бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй,*
- *Барилга дансанд бүртгэлтэй 384,772.7 мянган төгрөгийн дээврийн засвар, гадна фасадыг капиталжуулалгүйгээр тусдаа 3 хөрөнгө мэтээр бүртгэсэн,*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд *УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга"-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг*

*үнэн зөв толилуулах ёстой...”,* УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ[1]4-д *“... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...”, 19[2]-д “ ... хөрөнгөд тодорхой хэсгийг нэмэх ... буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.“ санхүүгийн тайлангийн* “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **88,873.1** мянган төгрөгийн 5 зөрчил[3] илэрснээс 6,434.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 13,522.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 68,916.6 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **19,956.5** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,918.8 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

**1**. Спорт заал болон дотуур байр түрээсэлсний 20 хувь болох 710.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, түрээслэх зөвшөөрлийг ОНӨГ-аас аваагүй байна. Энэ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2014 оны 25 тоот тогтоолын "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, түрээсийн төлбөрийн хэмжээг батлах тухай" 2 дугаар зүйлийн 2.4 дэх “*орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэх гэрээг орон нутгийн өмчийн албаар хянуулж батлуулсны дараа уг гэрээ хүчин төгөлдөр болно*”, 2.14 дэх “*түрээслүүлэгчийн түрээслэгчээс авч буй түрээсийн төлбөрийн нэгдсэн судалгаа гаргаж, түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 20 хувийг орон нутгийн хөрөнгө худалдан борлуулсны орлогын дансанд байршуулна*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>*:* Түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**2**. Тайлант онд өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй 6 ажилтанд 5,724.0 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”,* Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “*Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн* ***төрийн байгууллагад ажилласан хугацааг*** *харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас … бодож олгоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>*:* Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

---

[1] *ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж*

[2] *Байгууллага нь өөрийн бүх үндсэн хөрөнгийн өртөг зардлыг тэдгээрийн гарсан тэрхүү цаг хугацаанд үнэлнэ. Эдгээр өртөг зардал нь үндсэн хөрөнгийн зүйлсийг худалдан авах буюу барьж байгуулахад анх гарсан өртөг зардал болон хөрөнгөд тодорхой хэсгийг нэмэх, заримыг сольж орлуулах буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.*

[3] *Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.*

**3.2 Албан шаардлага**

**1**. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 34 ажилтанд 13,522.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *"Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ"* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**:

*1.1 Илрүүлэлт:* Гүйлгээ баланс дахь хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн дүн нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас 68,916.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",* 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь *"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

1. **Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**:

*1.2 Илрүүлэлт:* Аж ахуйн материалын дансанд бичиг хэрэг, барилгын материалыг, тусгай зориулалттай материалын дансанд хүнсний материалыг тусгай зориулалттай материал дансанд ангилан бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно",* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Ангилал" батламж мэдэгдлийг тус тус  зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Бараа материалыг зөв ангилан бүртгэж байх зөвлөмж хүргүүллээ.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй | 1 | 99,470.1 | | | 1 | 99,470.1 | | | | | | |
| Барилгын их засварыг капиталжуулан бүртгэхдээ буруу бүртгэсэн | 1 | 384,772.7 | | | 1 | 384,772.7 | | | | | | |
| **Дүн** | **2** | **484,242.8** | | | **2** | **484,242.8** | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Байр түрээсэлсний 20 хувь орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, түрээслэх зөвшөөрлийг ОНӨГ-аас аваагүй. | 1 | 710.0 | 1 | 710.0 | | | | | | | | |
| Гэрээт ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон | 1 | 5,724.0 | 1 | 5,724.0 | | | | | | | | |
| Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан бодож олгосон | 1 | 13,522.5 | | | 1 | 13,522.5 | | | | | | |
| Гүйлгээ баланс, дэлгэрэнгүй тайлангийн дүнг зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 68,916.6 | | | | | 1 | 68,916.6 | | | | |
| Бараа материалыг зөв ангилан бүртгээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **5** | **88,873.1** | **2** | **6,434.0** | **1** | **13,522.5** | **2** | **68,916.6** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 171 мэдээллээс 3 хугацаа хоцроосон | 1 | - | | | 1 | - | | |
| Дүн | **1** | **-** | | | **1** | - | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой | | | | | | | | |
| Хүнсний материалыг шаардлагагүйгээр нөөцөлсөн | 1 | 8,241.7 | | | 1 | 8,241.7 | | |
| **Дүн** | **1** | **8,241.7** | | | **1** | **8,241.7** | | |
| **Нийт дүн** | **2** | **8,241.7** | | | **2** | **8,241.7** | | |

## ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Тууврэт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |